

БАТЛАВ.
 ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
 ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР
 ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН Б.БОЛОР-ЭРДЭНЭ

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН
 АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
 ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцан албан тушаалтан
1.	Зам, тээврийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газрын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.	Жилдээ	25 сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, салбар зөвлөлд санал болгосон байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүд, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
2.	Зам, тээврийн яамны газрын даргын сул орон тоонд тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, санал болгож ирүүлсэн албан хаагчийг зохих журмын дагуу томилуулах	Тухай бүр	Тус яамны газрын даргын 4 сул орон тоонд тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга.
3.	Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Төмөр замын газрын даргын сул орон тоонд тусгай шалгалт зохион байгуулах хүсэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх.	Тухай бүр	Агентлагийн даргын 2 сул орон тоог нөхөх захиалгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
4.	Зам, тээврийн яамны дэргэдэх салбар зөвлөлд хамаарах төрийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн томилгоо, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих	Жилдээ	Иргэний нисэхийн ерөнхий газар, Төмөр замын газрын хүний нөөцийн томилгоонд нэг удаа хяналт шалгалт хийсэн байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга, Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга

5.	Зам, тээврийн яам болон харьяа байгууллагуудын төрийн албан хаагчийн тоо бүртгэл мэдээллийн цахим системийн хөтлөлтийг үнэн зөв, бүрэн хөтөлж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан байна.	1 дүгээр улиралд	Зам, тээврийн яам болон Төмөр замын газрын нийт 161 албан хаагчийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн систем дэх мэдээллийг бүрэн баталгаажуулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
6.	Харьяа байгууллагуудын хэмжээнд албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлуулах, өөрчлөлт оруулахад мэргэшил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, дэмжлэг үзүүлэх, хянаж Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.	Тухай бүр	Иргэний нисэхийн ерөнхий газар болон Төмөр замын газрын төрийн захиргааны албан тушаалын 60-аас доошгүй албан тушаалын тодорхойлолтыг хянаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
7.	Зам, тээврийн яам болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах	Жилдээ	Зам, тээврийн яам болон харьяа байгууллагуудын нийт 20 албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт болон мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
8.	Харьяа байгууллагуудын хүний нөөцийн албан хаагчдыг чадавхжуулах сургалт, семинарыг зохион байгуулах	Хоёрдугаар улиралд багтаан	Тус яамны харьяа байгууллагуудын хүний нөөцийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт семинарыг зохион байгуулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга
9.	Харьяа байгууллагуудын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа, сургалтын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэх	Жилдээ	Иргэний нисэхийн ерөнхий газар болон Төмөр замын газрын хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгаа, сургалтын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж зөвлөмжийг хүргүүлсэн байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Мэдээллийн технологи, стандартын хэлтсийн дарга

10.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, харьяа байгууллагуудын ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.	Гуравдугаар улиралд багтаан	Иргэний нисэхийн ерөнхий газар болон Төмөр замын газрын ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан байна.	Төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн, Хуулийн хэлтсийн дарга
11.	Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэл, өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажиллах	Тухай бүр	Холбогдох чиглэл, үүрэг даалгаврыг биелүүлж ажилласан байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
12.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй мэдээллийг яамны сайт болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулах	Тухай бүр	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Боловсруулсан:

ТАЗ-ийн салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга

Э.Бадамсүрэн

